

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2025/011/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 363

танай _____ ны № _____ Т

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.ЭРДЭНЭБУЛГАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүрэгхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 2,251.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 345.0 сая төгрөг, аймгийн төсвөөс 105.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөж нийт зарлагыг 3,976.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөж батлуулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 3,976.6 сая төгрөгийг баталж орон нутгийн төсвөөс 2,096.8 сая, үйл ажиллагааны орлогоос 345.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр байна. Орон нутгийн төсөв 1,864.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 202.2 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Орон нутгийн төсвөөс, үйл ажиллагааны орлого 430.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,037.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,807.3 сая

632502713

төгрөг болж, 769.6 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын нэр дээр бүртгэлтэй газар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, зам гүүр байгууламжтай холбоотой өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2023 онд 6 зорилтын хүрээнд 136 арга хэмжээ төлөвлөж 136 арга хэмжээг бүрэн биелэж 95.3 хувьтай дүгнэгджээ.

АДБОУС 2706. 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	859,327,330.79	1,452,037,041.56
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,037,668,261.11	5,807,342,954.60
Нийт хөрөнгийн дүн	5,896,995,591.90	7,259,379,996.16
Нийт өр төлбөрийн дүн	103,791,812.20	95,954,365.14
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,793,203,779.70	7,163,425,631.02
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,896,995,591.90	7,259,379,996.16
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	4,654,208,039.66	6,711,409,964.46
Үйл ажиллагааны зардлын дүн	4,327,089,346.21	5,302,962,769.14
Үйл ажиллагааны үр дүн	327,118,693.45	1,408,447,195.32
Үйл ажиллагааны бус үр дүн	770,000.00	38,225,344.00
Үйл ажиллагааны нийт үр дүн	326,348,693.45	1,370,221,851.32
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	726,985,604.60	8,541,778,579.27
Тайлант оны үр дүн		5,793,203,779.70
Эцсийн үлдэгдэл		1,370,221,851.32
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,632,256,838.66	5,799,613,224.74
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,938,033,482.75	3,778,463,768.37
Үйл ажиллагааны ЦМГ	694,223,355.91	2,021,149,456.37
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-1,084,408,847.00	-1,405,721,262.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-3,176,000.00	-101,678,410.00
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-393,361,491.09	513,749,784.37
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,051,686,728.88	658,325,237.79
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	658,325,237.79	1,172,075,022.16
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		3,110,588,455.85
Урсгал зардал		1,617,415,683.85
Хөрөнгийн зардал		1,391,494,362.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		3,666,030,827.52
Улсын төсвөөс санхүүжих		1,226,707,500.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		581,996,932.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Илрүүлэлт-1:

Аудитаар нийт 3,215.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 3,215.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож ажиллаа.

Төлбөрийн акт

Илрүүлэлт-1

Бүрэгхангай сумын худалдааны төвийн түрээсийн орлогыг 4,300.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч 1,084.2 мянган төгрөгийн орлого орж 3,215.8 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс,

орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага бичигдээгүй.

Зөвлөмж өгөөгүй.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ЗДТГ	1	7,600.0					1	7,600.0				
Дүн	1	7,600.0					1	7,600.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ТТЗ	1	3,215.8	1	3,215.8								
Бүрэгхангай сумын ЗДТГ	4	44189.3			1	5,300.0	2	22,191.3	1	16,698.0		
Бүрэгхангай сумын ИТХ	3	4,112.3	2	4,112.3			1	0				
Бүрэгхангай сумын Соёлын төв	2	1,019.1	1	120.0			1	899.1				
Бүрэгхангай сумын ОНХС	1	84,200.0					1	84,200.0				
Бүрэгхангай сумын ХХС	1	228.7					1	228.7				
Дүн	12	144565.3	4	7,448.1	1	5,300.0	9	107,519.2	1	16,698.0		

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүл

									лсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдааны төвийн түрээсийн орлогыг 4,300.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч 1,084.2 мянган төгрөгийн орлого орж 3,215.8 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.	1	3,215.80	1	3,215.80						
ИТХ-ын даргаар ажиллаж байсан үе үеийн дарга нарт хүндэтгэл үзүүлж төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. /мөнгөн аяга 380.0, Домбо 2520.0 мянган төгрөг/	1	2,900.0	1	2,900.0						
Албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээг 30 хувиар хэтрүүлэн олгосон.	1	1,212.3	1	1,212.3						
Хөвсгөл аймагт "Соёл урлагийн ажилтны өдөр"-т зориулсан хойд бүсийн соёлын салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах 2 өдрийн сургалтыг 2024.09.13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж 3 албан хаагч оролцож 1 өдрийн томилолт илүү олгосон.	1	120	1	120						
Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2024.11.11 А/33 тушаалаар мөрийн хөтөлбөрийн сэтгүүл хэвлүүлсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс мөрийн хөтөлбөрийн видео бичлэг хийлгэсэн, бараа үйлчилгээний бусад зардлаас 2,000.0 мянган төгрөгийн мөрийн хөтөлбөрийн сэтгүүлийн эх бэлтгэхэд зарцуулсан.	1	5,300.0			1	5,300.0				
Нийгмийн даатгал 2948.4, гэрэл цахилгаан 894.3, байгууллагад төлөх 311.6 мянган төгрөгийн өглөгтэй.							1	4,154.3		
Байгууллагаас авах буюу бусад зардлын тооцооны 18,037.0 мянган төгрөгийн авлагатай.							1	18,037.0		
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн							1	-		
Бүрэгхангай сумын ИТХ нь хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүй							1	-		
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн							1	-		
Ажилчидтай холбоотой 899.1 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөг үүссэн.							1	899.1		
Шилэн дансны 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн							1	-		
"Ану сервис" ХХК, халуун ус 00 дутуу санхүүжилтийг бүрэн олгоогүй өглөг үүссэн.							1	84,200		
Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд хүүгийн орлогоос зарцуулах эрхийг ИТХ-аар батлуулаагүй бичиг хэрэг 190.0, ХХС-гийн зээлийн хяналт шалгалтын зардал 38.7 мянган төгрөгийг зарцуулсан.							1	229		
Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/280 дугаар захирамжаар 973.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах шийдвэр гаргасан боловч бараа үйлчилгээний зардлаас, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/283 дугаар тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэр гаргасан ч 125.0 мянган төгрөгийг нэг удаагийн шагнал урамшууллаас хяналтгүйгээр гаргасан байна. Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны их засвараас үүссэн 8,000.0 мянган төгрөгийн өглөг үүссэн 2023 оны санхүүгийн тайланд тусгаагүй нуун дарагдуулсан,								1	16,698.0	

сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт наадмын цогцолбор барихад цемент дутагдаж 1200 шуудай буюу 60 тн цемент Булган сумын иргэн Н.Дэмчигсүрэнгээс ачуулан хүргүүлсэн, төлбөр мөнгийг 100 жилээс өмнө шилжүүлэх байсан 1 шуудай цемент тухай үеийн ханш 23,000.0 төгрөг, 1200 ширхэг нь 27,600,000 төгрөгийн өглөг үүссэнийг өглөгөөр тусгаагүй 2024 оны 12 дугаар сарын 27-нд 20.0 сая төгрөгийг тухайн хүн рүү шилжүүлж 7.6 сая төгрөгийн өглөг үүссэн.													
Нийт дүн	5	136,9 65.2	4	7,44 8.10	1	530 0.0	9	107,5 19.1	1	16,69 8.0	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Бүрэгхангай сумын ЗДТГ	1	0			1	0
Бүрэгхангай сумын ИТХ	1	0			1	0
Бүрэгхангай сумын Соёлын төв	1	0			1	0
Дүн	3	0			3	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						